

БАТЛАВ
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,
ГАМШГААС ХАМГААЛАХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН УЛСЫН АЛБАНЫ ДАРГА
С.ЭНХБОЛД

**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАРТАХЛЫН ҮЕИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН УЛСЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ШИНЭЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2021.08.24

Үндэслэл:


Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр коронавируст халдвар (КОВИД-19)-ыг үүсгэгч SARS-CoV-2 вирусын альфа, бета, гамма, дельта зэрэг анхаарал татаж буй мутацлагдсан хувилбарууд бүртгэгдэж, 201 улс орон, нутаг дэвсгэрт тархаад байна. Ялангуяа Дельта хувилбарын вирус нь 148 улсад бүртгэгдсэн ба SARS-CoV-2 бусад хувилбараас халдварлуулах чадвар өндөр буюу 1 хүн дунджаар 3-5 хүнд халдвар тараах эрсдэлтэй байна.

Монгол улсад 2021 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар нийт 196.841 хүн коронавируст халдвараар өвчилсөн бөгөөд зөөвөрлөгдсөн халдвар 594 (нийт халдварын тохиолдлын 0.3%), дотоодын халдвар 195.950 (нийт халдварын тохиолдлын 99.5%), бүртгэгдээд байна. Манай Улсын хэмжээнд коронавируст халдварын тархалтын үе шатны үнэлгээгээр Нийслэл хот болон 17 аймагт халдварын тархалт “улаан”, Баянхонгор, Дорнод аймагт “улбар шар”, Өмнөговь, Дорноговь аймагт “шар түвшинд” байна.

Улсын хэмжээнд 951 сорьцод ПГУ шинжилгээ хийхэд 243 (24.8%) сорьцод Дельта хувилбарын вирус илэрчээ. Үүнээс тархвар судлалын 33 дугаар долоо хоногт 489 сорьцод шинжилгээ хийхэд 170 сорьцод дельта хувилбар тодорхойлогдон эерэг илрэлт 34.7 хувьд хүрч нэмэгдэж байна. Дельта хувилбараар өвчилсөн тохиолдлын 91 (37.4%) нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн байна.

2021 оны 8 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд Улаанбаатар хот, Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Ховд, Хэнтий аймгаас цуглуулсан 331 сорьцыг шинжлэхэд 105 сорьц (31.7%)-д Дельта хувилбарын вирус тодорхойлогджээ. Мөн тархвар судлалын 31-33 дугаар 7 хоногт 41 удаагийн нислэгээр ирсэн коронавируст халдварын эсрэг вакцины бүрэн тунд хамрагдсан 3,660 хүнийг “Чингис хаан ОУНОБ”-ын хилийн нэвтрэх цэгийн лабораторид суурилсан тандалтаар 33 (0.9 хувь) хүнээс коронавирус (КОВИД-19) илэрчээ. Түүнчлэн 8 дугаар сарын 22-ны өдрийн Истанбул-Улаанбаатарын чиглэлийн онгоцоор ирсэн коронавируст халдварын эсрэг вакцины бүрэн тунд хамрагдсан 31 хүнээс мөн коронавирус (КОВИД-19) илэрсэн байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хандлагыг вакцины идэвхтэй уялдуулан таамаглал гаргахад 9-10 дугаар сард өвчлөл оргил үедээ хүрч, өдөрт бүртгэгдэх тохиолдлын тоо 2500 болох магадлал өндөр байна (Зураг 1).




Дэлхий дахинд болон Монгол Улсад коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эрчим буурахгүй, дельта хувилбарын вирусийн тархалт нэмэгдэж байгаа, манай улсад томуу, томуу төст өвчний улирал эхэлж байгаа, хичээлийн шинэ жилтэй холбоотой хүн амын нягтрал ихсэж байгаа, хилийн нэвтрэх цэгт коронавир (КОВИД-19)-ын эсрэг вакцины бүрэн тунд хамрагдсан иргэдээс халдвар илэрч байгаа нь эрсдэлийг эрс нэмэгдүүлж байна.

Зорилго:

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цартахлын хувьсан өөрчлөгдөж буй нөхцөл байдлыг цаг алдалгүй үнэлж, тусламж үйлчилгээний өсөн нэмэгдэх хэрэгцээг хангах зорилгоор эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зохицуулалт хийх, хохирол багатай даван туулахад энэхүү төлөвлөгөөний зорилго оршино.

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн болно. Үүнд:

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг эрүүл мэндийн салбарын хариу арга хэмжээний удирдлагын бүтцийг оновчтой зохион байгуулах;
2. Нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламжийн хариу арга хэмжээг нөхцөл байдалд тохируулан оновчтой зохион байгуулах;
3. Хүний нөөцийн бэлэн байдлыг хангах, дайчлах, эмч, эмнэлгийн ажилчдын чадавхыг дээшлүүлэх, сайн дурын идэвхтний оролцоог нэмэгдүүлэх;
4. Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн бэлэн байдал хангаж, тасралтгүй нөхөн хангалт хийх;
5. Эрүүл мэндийн бусад тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах;
6. Эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнг тухай бүр шийдвэр гаргалтад ашиглах;
7. Хариу арга хэмжээний санхүүжилтийг төлөвлөх, зарцуулах;



8. Бүртгэл, мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, бүрэн цахимжуулах, аюулгүй байдлыг хангах;
9. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хариу арга хэмжээнд салбар хоорондын байгууллагын оролцоог хангах, хамтран ажиллах;
10. Хилийн нэвтрэх цэгийн хяналтыг сайжруулж, лабораторит суурилсан тандалт судалгаа хийх, хариу арга хэмжээ авах;
11. Төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, зөвлөмж гарган хэрэгжүүлэх.

Төлөвлөгөөний бүтэц:

1. Хариу арга хэмжээ
 - 1.1. Удирдлага, зохион байгуулалт
 - 1.2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
 - 1.3. Эмнэлгийн тусламж үйлчилгээ
 - 1.4. Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
2. Хүний нөөц
3. Эм, эмнэлгийн хэрэгслийн ханган нийлүүлэлт, нөөц
4. Эрүүл мэндийн бусад тусламж үйлчилгээ
5. Эрдэм шинжилгээ, судалгаа
6. Санхүүжилт
7. Бүртгэл, мэдээлэл
8. Салбар хоорондын хамтын ажиллагаа
9. Хилийн нэвтрэх цэгийн хяналт
10. Шалгуур үзүүлэлт
11. Хавсралтууд (халдварын нөхцөл байдал, тооцоололд үндэслэн нарийвчилан гаргасан)

Хугацаа:

2021 оны 9 дүгээр сараас 2022 оны 3 дугаар сар

Хэрэгжүүлэх байгууллага:

Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын алба, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Цус судлалын үндэсний төв зэрэг байгууллага болно.

Хүрэх үр дүн:

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цартахлын нийгмийн эрүүл мэндийн болон тусламж үйлчилгээг оновчтой, хүртээмжтэй зохион байгуулснаар:

- эрүүл мэндийн тогтолцооны хүчин чадал шавхагдахаас сэргийлэх;



- халдварын үе шатаас хамаарч, өвчтөнүүдийг эрэмбэлэн ангилж эмнэлгийн тусламж үйлчилгээг тохиромжтой газар (эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн бус орчин, гэрт гм)-т тусламж үйлчилгээ үзүүлэх;
- эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай бусад тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах;
- хариу арга хэмжээний нөөцийг тасралтгүй бүрдүүлж, оновчтой зарцуулах ач холбогдолтой юм.




**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАРТАХЛЫН ҮЕИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
УЛСЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЭЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Арга хэмжээ	Хугацаа	Хариуцах газар, хэлтэс	Хамтран байгууллага	Шалгуур үзүүлэлт
НЭГ. ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ					
1.1. Хариу арга хэмжээ (удирдлага, зохион байгуулалт)					
1	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын удирдлага зохион байгуулалтын зураглал, чиг үүрэг гаргах (хавсралт 1)	8-р сарын 18	ХШҮГ	ТЗУГ	Зураглал, чиг үүрэг гарсан байна.
2	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хариу арга хэмжээний тушаал, шийдвэрийн давхардал, хийдэл арилгах ажлын хэсэг байгуулах, тушаалыг шинэчлэх	8-р сарын 30	ТЗУГ	НЭМТБХЗГ, ЭТБХЗГ, ХШҮГ	Тушаал, шийдвэрийн давхардал арилсан байна.
1.2. Хариу арга хэмжээ (Нийгмийн эрүүл мэнд)					
3	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалт, хавьтлын судалгааны зураглал, алгоритм гаргах (хавсралт 2)	8-р сарын 25	НЭМТБХЗГ	ХӨСҮТ	Зураглал, алгоритм гаргасан байна.
4	Өвөрмөц кластерийг нарийвчлан судлах, зөвлөмж гаргах	Тухай бүр	ХӨСҮТ	НЭМТБХЗГ	Дэгдэлтийн судалгаа хийгдсэн байна.
5	Эмнэлэгт болон эмийн санд суурилсан тандалт хийх, үр дүнг тооцох	Тухай бүр	ХӨСҮТ	НЭМТБХЗГ	Тандалт хийгдсэн байна.
6	Коронавируст халдвар тархалтын үе шатанд боловсролын байгууллагад мөрдөх тусгай шаардлага гарган мөрдүүлэх (хавсралт 3)	8-р сарын 25	НЭМТБХЗГ	БШУЯ	Тусгай шаардлага гарсан байна.
7	Боловсролын байгууллагад коронавируст халдварын тандалт хийх	Тухай бүр	ХӨСҮТ	НЭМТБХЗГ	Тандалт хийгдсэн байна.
8	Коронавируст халдварын ойрын хавьтлын тандалтад эргэмж судалгаа хийх	8-9-р сард	ХӨСҮТ	НЭМГ	Эргэмж судалгаа хийгдсэн байна.
9	Эрүүл мэндийн ажилтнуудын өвчлөлд дүн шинжилгээ хийж, зөвлөмж гаргах	8-9-р сард	ХӨСҮТ	НЭМГ	Эргэмж судалгаа хийгдсэн байна.
10	Томуугийн харуулдан тандалтын тогтолцоог идэвхжүүлэх	Тогтмол	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	7 хоног тутмын эргэн мэдээлэл гарсан байна.
11	Гадаадаас ирсэн иргэдийн гэрийн хяналт тандалт хийх	Тогтмол	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	Гэрийн хяналтын тайлан гарсан байна.
12	Коронавируст халдвар (КОВИД-19)-ыг амьтны хүрээлэн ажиллуулдаг, ан амьтан сэргээн нутагшуулах, үржүүлэх, туршилт судалгааны ажил эрхэлдэг	8-9-р сард	ЗӨСҮТ	Орон нутгийн ЗӨСТ, мал эмнэлгийн байгууллага	Тандалт хийж, үр дүнг мэдээлсэн байна.



	байгууллагуудад хамтарсан тандалт хийх				
13	Халдвар тархалтын үе шатанд тохирсон эрсдэлийн харилцаа холбооны төлөвлөгөө, зураглалыг шинэчлэх	8-р сарын 30	НЭМТБХЗГ	НЭМҮТ	Төлөвлөгөө, зураглал шинэчлэгдсэн байна.
14	SARS-CoV-2 анхаарал татсан мутацлагдсан вирусийн талаар олон нийтэд мэдээлэл өгөх	Тухай бүр	ХӨСҮТ	НЭМТБХЗГ, харилцаа холбооны баг	Мэдээлэл олон нийтэд хүрсэн байна.
15	Цахим тандалт хийж, буруу ташаа мэдээллийг тухай бүр залруулах	Тухай бүр	НЭМҮТ	НЭМТБХЗГ, харилцаа холбооны баг	Цахим тандалтын мэдээ, тайлан гарсан байна.
16	18-аас дээш насны иргэдийг коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины дархлаа сэргээх тунд хамруулах (хавсралт 4)	Төлөвлөгөө ний дагуу	НЭМТБХЗГ	ХӨСҮТ, НЭМГ	Вакцинжуулалтын хувь
17	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлд нарийвчилсан судалгаа хийх	9-р сард	НЭМТБХЗГ	ХӨСҮТ, НЭМГ	Судалгаа хийгдсэн байна.
18	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинд хамрагдаад халдвар авсан иргэдийн дунд нарийвчилсан судалгаа хийх	9-р сард	НЭМТБХЗГ	ХӨСҮТ, НЭМГ	Судалгаа хийгдсэн байна.
19	Улирлын томуугийн эсрэг вакцинаар зорилтот бүлгийн хүн амыг дархлаажуулах	9-10-р сард	НЭМТБХЗГ	ХӨСҮТ, НЭМГ	Эрсдэлт бүлгийг хамруулсан байна.
1.3. Хариу арга хэмжээ (Эмнэлгийн тусламж үйлчилгээ)					
20	Коронавируст халдварын нөхцөл байдалтай уялдуулсан эмнэлгийн ор дэлгэх болон буулгах төлөвлөлт батлуулах (хавсралт 5)	9-р сарын 10	ЭТБХЗГ	Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллагууд	Төлөвлөгөө батлагдсан байна.
21	Эмзэг болон зорилтот бүлэг (өндөр настан, дархлаа дарангуйлагдсан архаг хууч өвчтэй хүмүүс, жирэмсэн болон хөхүүл эхчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, урт хугацааны асаргаа, сувилгаа бүхий хүмүүс)-т чиглэсэн тусламж, үйлчилгээний удирдамж, зааварт тодотгол хийх	Шаардлага -тай тохиолдолд	ЭТБХЗГ, НЭМХБЗГ	Мэргэжлийн салбар зөвлөл	Удирдамж заавар шинэчлэгдсэн байна.
22	Коронавируст халдвар (КОВИД-19)-тай холбогдон гарсан тушаал, дүрэм, зааврын нэгтгэл гарын авлага боловсруулах, эрүүл мэндийн байгууллагуудад түгээх	11-р сар	ЭТБХЗГ	Шуурхай багийн Мэдээлэл, харилцаа холбооны хэсэг	Гарын авлага гарсан байна.
23	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын шалтгааны улмаас нас барсан тохиолдлуудад эргэмж судалгаа хийх	Сар бүр	ЭТБХЗГ, ЭСҮТ	Эрүүл мэндийн байгууллагууд, МСЗөвлөл	Судалгааны тайлан гарсан байна.



24	ПГУ шинжилгээ хийж байгаа молекул биологийн лабораториудын үйл ажиллагаанд үнэлгээ хийх	8-9-р сард	ЭТБХЗГ	ХӨСҮТ, МСЗөвлөл	Үнэлгээ хийгдсэн байна
25	Коронавируст халдвар (КОВИД-19) илрүүлэх оношлуурыг яаралтай нөхцөлд хэрэглэх зөвшөөрөл олгох журмыг батлуулах	8-р сард	ЭТБХЗГ	ЭЭХХЗГ	Журам батлагдсан байна
26	Эмнэл зүйн удирдамжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, нэмэлт өөрчлөлт оруулах	Тухай бүрт	ЭТБХЗГ, Эрүүл мэндийн байгууллага	Мэргэжлийн салбар зөвлөл	Журам шинэчлэгдсэн байна.
27	Эрүүл мэндийн үндсэн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, хяналт тавих	Тогтмол	ЭТБХЗГ, ЭМДЕГ	Аймаг, нийслэлийн ЭМГ	Тусламж үйлчилгээ хэвийн байна.
28	Анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэмжлэгт хяналт хийх	Тогтмол	ЭТБХЗГ, ЭМДЕГ	Аймаг, нийслэлийн ЭМГ	Тусламж үйлчилгээ хэвийн байна.
29	Иргэдэд зориулсан "Хамтдаа давах туулья" гарын авлагыг шинэчлэн боловсруулж хэвлүүлэн түгээх	9-р сард	ЭТБХЗГ, СЭМҮТ, НЭМҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	Гарын авлага гарсан байна.
30	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын дараах сэргээн засах тусламж үйлчилгээний заавар боловсруулж батлуулах	9-10-р сард	ЭТБХЗГ	МСЗөвлөл	Заавар боловсруулагдсан байна.
31	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын шалтгаант эхийн эндэгдэлд дүн шинжилгээ хийж, жирэмсэн эмэгтэйн эмнэлзүйн явцын онцлогийг тодорхойлох	8-9-р сард	ЭТБХЗГ	МСЗөвлөл	Тайлан, дүгнэлт гарсан байна.

1.4. Өрхийн тусламж үйлчилгээ

32	Нийслэлийн өрхийн эрүүл мэндийн төвүүдийн коронавируст халдвар (КОВИД-19)-ын дельта хувилбарын тархалтын үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх (хавсралт 6)	Өвчлөлийн үе шатаар	ЭТБХЗГ	НЭМГ	Төлөвлөгөө бүрэн хэрэгжсэн байна.
----	---	---------------------	--------	------	-----------------------------------

ХОЁР. ХҮНИЙ НӨӨЦ

33	Салбарын одоо байгаа хүчин чадал, хүний нөөцийг тодорхойлж хэрэгцээтэй байгаа мэргэшлийн эмч эмнэлгийн мэргэжилтний хэрэгцээг тодорхойлж тооцооллыг гаргах (хавсралт 7)	8-р сард	ТЗУГ-СТХ, Эрүүл мэндийн хөгжлийн төв	ЭТБХЗГ, Орон нутгийн түвшинд - Аймаг, нийслэлийн ЭМГ	Тооцоолол гарсан байна.
34	"Коронавируст /КОВИД-19/ халдварын үеийн хүний нөөцийн бэлэн байдлыг хангах, Эрүүл мэндийн ажилчдыг чадавхижуулах сургалтын нэгдсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах (хавсралт 8)	Тухай бүр	ЭМХТ, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага	Мэргэжлийн салбар зөвлөл	Нэгдсэн төлөвлөгөө гарсан байна.



35	Эрчимт эмчилгээ, яаралтай тусламж, эх барих, эмэгтэйчүүд, лабораторийн эмч, эмнэлгийн мэргэжилтний хүртээмжийг нэмэгдүүлэх төлөвлөлт, зохицуулалт хийх (хавсралт 9)	8-12-р сард	ТЗУГ-СТХ, ЭМХТ, сургалт эрхлэх байгууллага	ЭТБХЗГ, Орон нутгийн түвшинд - Аймаг, нийслэлийн ЭМГ	Төлөвлөлт хийгдсэн байна.
36	Хүний нөөцийг чадавхижуулах ажлын байрны сургалт, сургалтын материалыг цахим хэлбэрээр түгээх, Телемедицина ашиглан цахимаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх "Хөдөлгөөнт баг" бэлтгэх	8-9-р сард	ТЗУГ-СТХ, ЭМХТ	ЭТБХЗГ, Эмнэлзүйн зөвлөх баг, НЭМГ, эрүүл мэндийн байгууллага	Сургалтын материал цахим хэлбэрээр тавигдсан байх
37	Үндсэн мэргэшлийн 4 чиглэлээр төгссөн эмч нарыг дайчлан ажиллуулах (хавсралт 10)	8-12-р сард	ТЗУГ-СТХ, ЭТБХЗГ, ЭМХТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллагууд	Дайчлан ажиллах төлөвлөгөө гарсан байна.
38	Эрчимт эмчилгээ, Яаралтай тусламж, Дотрын анагаах ухаан, Лабораторийн резидентийн элсэлтийг зохион байгуулах, дайчлан ажиллуулах (хавсралт 11)	8-12-р сард	ТЗУГ-СТХ, ЭМХТ	ЭТБХЗГ, Төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллагууд	Төлөвлөгөө гарсан байна.
39	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 30%-ийн эмч, сувилагчийг дайчлан ажиллуулах (хавсралт 12)	8-12-р сард	ЭМХТ, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага	ТЗУГ, ЭТБХЗГ	Төлөвлөгөө гарсан байна.
40	Ариутгагч, хүчилтөрөгчийн техникч бэлтгэх 1 сарын сургалтад тухайн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа ажилтнаас сонгон авч суралцуулах	8-р сард	ТЗУГ-СТХ, ЭТБХЗГ-ын ЛШТХ	ЭМХТ, Эрүүл мэндийн байгууллагууд	Төлөвлөгөө гарсан байна.
41	Тусгаарлан ажиглах байранд "Улаан загалмай" нийгэмлэгийн сайн дурын 100 ажилтныг сургалтад хамруулж дайчлан ажиллуулах	8-9-р сард	ТЗУГ-СТХ, ЭТБХЗГ-ын ЛШТХ, МУЗН	УОК, ЭМХТ	Сургалт зохион байгуулагдсан байна.
ГУРАВ. ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ, НӨӨЦ					
42	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үеийн Антибиотикийн хэрэглээний судалгаа хийх	Хагас жилд	ЭЭХХЗГ	Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллагууд	Антибиотикийн хэрэглээний судалгаа хийгдсэн байна.
43	Эрүүл мэндийн ажилтнуудын хувийн хамгаалах хэрэгслийн нөөцөд хяналт тавьж, хангалт хийх	Тогтмол	ТЗУГ-СТХ, ЭЭХХЗГ	Шуурхай багийн Санхүү, нөөц, хангалтын хэсэг	Тасралтгүй байдал хангагдсан байна
44	Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцөд байнга хяналт тавих	Тогтмол	ЭЭХХЗГ	Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл	Тасралтгүй байдал хангагдсан байна



				мэндийн байгууллагууд	
45	Эрүүл мэндийн байгууллагуудад нэн шаардлагатай байгаа эмнэлгийн тоног төхөөрөмж болон хэрэгслийн бүртгэл хийж шинэчлэх	Сар бүр	ЭМЭЗБХГ- ХОХ	ЭЭХХЗГ	Бүртгэл, судалгаа хийгдсэн байна.
46	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын хариу арга хэмжээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн зах зээлийн судалгаа хийх	Тухай бүрт	ЭМЭЗБХГ- ХОХ	ЭЭХХЗГ, ХӨСҮТ	Судалгаа хийгдсэн байна.
47	Эрүүл мэндийн байгууллагуудад нэн шаардлагатай хүчилтөрөгчийн тоног төхөөрөмжийн судалгаа хийх, сонгогдсон аймагт хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр байгуулах	Улирал бүр	ЭМЭЗБХГ- ХОХ	ЭЭХХЗГ, ОУБ	Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр байгуулагдсан байна
48	Эрүүл мэндийн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгслийн 14 хоногийн нөөцийн судалгааг тогтмол гарган, хангалт хийх	7 хоног тутам	ЭМЭЗБХГ- ХОХ	ЭЭХХЗГ	Нөөцийн судалгаа гарсан байна.
49	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед хэрэглэгдэж байгаа Ремдесивир, Фавипиравир вирусийн эсрэг эмийн үр нөлөө, эрсдэлийн үнэлгээ хийх	10-р сар	ЭЭХХЗГ	ХӨСҮТ, УНТЭ, УГТЭ, АШУУИС-МЯЭ	Судалгааны үр дүн гаргаж танилцуулсан байна.
50	Тозилизумаб эмийн коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг үзүүлэх үр нөлөө, эрсдэлийн үнэлгээ хийх	12-р сар	ЭЭХХЗГ	Ажлын хэсэг	Судалгааны үр дүн танилцуулсан байна.
51	ДЭМБ-ын Олон улсын эмийн аюулгүй байдлын хяналтын хөтөлбөрт элсэх, эм, вакцины гаж нөлөөний мэдээлэл солилцох	11-р сар	ЭЭХХЗГ	ДЭМБ	Уппсала хяналтын төвийн жинхэнэ гишүүн болсон байна.
ДӨРӨВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН БУСАД ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАСРАЛТГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ					
52	Цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэх, аюулгүй байдлыг ханган ажиллах (хавсралт 13)	Тогтмол	ЭТБХЗГ, ЦССҮТ	УОК, НОК, Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллагууд	Тасралтгүй байдал хангагдсан байна.
53	Эрүүл мэндийн үндсэн тусламж үйлчилгээг зохицуулах	Тогтмол	ЭТБХЗГ	Эрүүл мэндийн байгууллагууд	Эмнэлгийн тусламж үйлчилгээ хэвийн явагдсан байна.
54	"Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үеийн сэтгэцийн тусламж үйлчилгээ үзүүлэх гарын авлага" боловсруулж, цахим сургалт зохион байгуулах	2021 оны 11-р сард	ЭТБХЗГ	СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ тасралтгүй явагдсан байна

ТАВ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА



55	"Монголд илэрсэн SARS-CoV-2 омгуудын геномын бүтцийг тодорхойлж, молекул эпидемиологийн онцлогийг тооцон, онош, тандалт, сэргийлэлтийн манай орны нөхцөлд тохирсон аргачлал зөвлөмж гаргах" судалгаа хийх	2020-2021	ТЗУГ, СТХ	АШУУИС, НЭМҮТ, ХӨСҮТ, ЗӨСҮТ	Судалгааны үр дүн гарсан байна.
56	"Монгол улсад бүртгэгдсэн коронавируст халдвар (КОВИД-19)-ийн эмнэлзүйн судалгаа" хийх	2020-2021	ТЗУГ, СТХ	АШУУИС, НЭМҮТ, ХӨСҮТ, ЗӨСҮТ	Судалгааны үр дүн гарсан байна.
57	"Монгол улсад SARS-CoV-2 голомтолсон халдварын геномын судалгаа" хийх	2020-2021	ТЗУГ, СТХ	АШУУИС, НЭМҮТ, ХӨСҮТ, ЗӨСҮТ	Судалгааны үр дүн гарсан байна.
58	Коронавирус (2019-nCoV)-ийн халдвартай эхний тохиолдлууд болон хавьтлуудыг судлах протокол гаргах, судалгаа хийх	2020-2021	ТЗУГ, СТХ	АШУУИС, НЭМҮТ, ХӨСҮТ, ЗӨСҮТ	Судалгааны үр дүн гарсан байна.
59	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтыг хүн амд суурилан, насны бүлэг тус бүр судлах тархвар зүйн протокол гаргах, судалгаа хийх	2020-2022	ТЗУГ, СТХ	АШУУИС, НЭМҮТ, ХӨСҮТ, ЗӨСҮТ	Судалгааны үр дүн гарсан байна.
60	КОВИД-19 вакцины дархлаа тогтоцын түвшинг судлах	2021-2022	ТЗУГ, СТХ	АШУУИС, НЭМҮТ, ХӨСҮТ, ЗӨСҮТ	Судалгааны явцын үр дүн гарсан байна.
61	Монгол улсад голомтлон тархаж буй SARS-CoV2 омогт бх-ПГУ аргаар өвөрмөц мутаци нуклейн хүчлийн дараалал тогтоох шинжилгээ хийх, шинэ технологи нэвтрүүлэх	2021-2022	ТЗУГ, СТХ	АШУУИС, НЭМҮТ, ХӨСҮТ, ЗӨСҮТ	Судалгааны явцын үр дүн гарсан байна.
62	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын болон вакцины дараах дархлааны хамгаалах идэвхийн судалгаа хийх	2021-2022	ТЗУГ, СТХ	АШУУИС, НЭМҮТ, ХӨСҮТ, ЗӨСҮТ	Судалгааны явцын үр дүн гарсан байна.
ЗУРГАА. САНХҮҮЖИЛТ					
63	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хариу арга хэмжээнд шаардлагатай санхүүжилтийг зардлын төрлөөр нарийвчлан гаргах (хавсралт 13)	8-р сарын 30	ЭМЭЗБХГ	Эрүүл мэндийн байгууллагууд	Нарийвчилсан төлөвлөгөө гарсан байна.
ДОЛОО. БҮРТГЭЛ МЭДЭЭЛЭЛ					
64	tandalt.gov.mn цахим програмд тушаал шийдвэртэй уялдуулан хөгжүүлэлт хийх	Тухай бүр	МТХ	ХӨСҮТ, ЭМХТ	Хөгжүүлэлт хийгдсэн байна.
65	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын мэдээллийн тогтолцооны журмын хэрэгжилтэд хяналт тавих	Тухай бүр	МТХ	ХӨСҮТ, ЭМХТ	Мэдээлэл нэг чиглэлийн урсгалтай болно
66	Цахим програмын аюулгүй болон тасралтгүй ажиллагаанд хяналт тавих, доголдлыг арилгах	Тухай бүр	МТХ		Системийн найдвартай байдал хангагдана.
НАЙМ. САЛБАР ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА					



67	УОК болон бусад салбартай хамтран ажиллах, хариу арга хэмжээг зохион байгуулах	Тухай бүр	Шуурхай штаб	ХӨСҮТ, ЗӨСҮТ	Хариу арга хэмжээ авч ажилласан байна.
68	Коронавируст халдварын нөхцөл байдлын мэдээллээр бусад салбарыг хангах	Өдөр бүр	НЭМТБХЗГ	ХӨСҮТ, ЗӨСҮТ	Нэгдсэн мэдээллээр хангасан байна.
ЕС. ХИЛИЙН НЭВТРЭХ ЦЭГИЙН ХЯНАЛТ					
69	Чингис хаан ОУНОБ-ын хилийн нэвтрэх цэгт лабораторид суурилсан тандалт хийх, мэдээлэл солилцох	Тухай бүр	ХӨСҮТ МХЕГ	НЭМТБХЗГ	Хилийн нэвтрэх цэгийн хяналт сайжирсан байна.
АРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ					
70	Төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт боловсруулах (хавсралт 14)	8-р сарын 18	ХШҮГ		Шалгуур үзүүлэлт гарсан байна.
71	Шалгуур үзүүлэлтийн дагуу 7 хоног тутам үнэлэх	7 хоног тутам	ХШҮГ		Шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, зөвлөмж гарсан байна.

Хавсралт ... хуудастай.

Хянасан:

Төрийн нарийн бичгийн дарга,
Гамшгаас хамгаалах Эрүүл мэндийн
улсын албаны штабын дарга

Ц. Эрдэмбилэг Ц.Эрдэмбилэг

Боловсруулсан:

ТЗУГ-ын дарга
НЭМТБХЗГ-ын дарга
ЭМТБХЗГ-ын дарга
ХШҮГ-ын дарга
ХОХ-ийн дарга
Штабын Шуурхай багийн зохицуулагч
Шуурхай багийн гишүүд

П. Эрхэмбаяр П.Эрхэмбаяр
Л. Энхсайхан Л.Энхсайхан
Б. Буянтогтох Б.Буянтогтох
С. Төгсдэлгэр С.Төгсдэлгэр
Т. Хонгорзул Т.Хонгорзул
Д. Баярболд Д.Баярболд



ХАВСРАЛТ 1. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАРТАХАЛТАЙ ТЭМЦЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цартахалттай тэмцэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах, шуурхай зохион байгуулах, хяналт тавих, салбар хоорондын уялдаа холбоог хангах чиг үүргийг үндэсний хэмжээнд Улсын онцгой комисс (УОК), түүний Шуурхай штаб, орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комисс хэрэгжүүлнэ.


Эрүүл мэндийн салбарын хэмжээнд коронавируст халдвар (КОВИД-19)-ын цартахалттай тэмцэх үйл ажиллагааг мэргэжлийн удирдлага, арга зүй, нэгдсэн зохицуулалтаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүргийг Эрүүл мэндийн сайдаар ахлуулсан Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын алба (ГХЭМУА), түүний Шуурхай баг хэрэгжүүлнэ. ГХЭМУА нь салбарын эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн зөвлөх багуудыг байгуулж болно.

ГХЭМУА нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргаар ахлуулсан орон нутгийн гамшгаас хамгаалах эрүүл мэндийн алба, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар (ЭЭХХЗГ), Халдварт өвчин судлалын үндэсний төв (ХӨСҮТ), Зоонозын өвчин судлалын үндэсний төв (ЗӨСҮТ), Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (НЭМҮТ), Эрүүл мэндийн хөржлийн төв (ЭМХТ) болон бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжлийн удирдлагаар ханган ажиллана.

Коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх эрүүл мэндийн салбарын хариу арга хэмжээний удирдлага, зохион байгуулалтын бүтцийн бүдүүвч, чиг үүргийг Зураг 1, Хүснэгт 1-д хураангуйлав.



Улсын онцгой комисс



Зураг 1. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх эрүүл мэндийн салбарын хариу арга хэмжээний удирдлага, зохион байгуулалтын бүтцийн бүдүүвч



Хүснэгт 1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цартахалтай тэмцэх эрүүл мэндийн салбарын хариу арга хэмжээний удирдлага, зохион байгуулалтын бүтцийн чиг үүрэг

Зохион байгуулалтын бүтцийн нэгж		Чиг үүрэг
ГХЭМУА	<ol style="list-style-type: none"> 1. Салбарын хэмжээнд цартахалтай тэмцэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд шаардлагад төсвийг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах; 2. Дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах; 3. Цартахлын мэдээ, тайлан, эрсдэлийн үнэлгээний дүгнэлтэд үндэслэн тухай бүр УАБЗ, УОК, Шуурхай штабыг цаг үеийн мэдээллээр хангах, Засгийн газрын хуралдаанд санал хүргүүлж, холбогдох шийдвэрийг гарлуулах 4. Салбарын тогтвортой ажиллагааг хангах; 5. Салбарын зарлан мэдээллийн системийн байнгын бэлэн байдлыг хангах; 6. Шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, хуваарилах, түгээх, зарцуулалтад хяналт тавих; 7. Орон нутгийн гамшгаас хамгаалах эрүүл мэндийн албыг мэргэжлийн удирдлагаар хангах; 8. Холбогдох дүрэм, журам, удирдамж, заавар, стандартыг боловсруулж, батлуулах. 	
ГХЭМУА-ны Штаб	<ol style="list-style-type: none"> 1. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах, хойшлуулалгүй арга хэмжээнд татан оролцуулах, техник, материал, хэрэгсэл зэрэг тухайн албанд шаардлагад нөөцийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, хяналт тавих; 2. Эрсдэлийг бууруулах, салбарын тогтвортой ажиллагааг хангах ажлыг зохион байгуулах; 3. Үйл ажиллагаанд шаардлагатай мэдээ, мэдээллийг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, бусад улсын болон орон нутгийн албанаас гаргуулан авах, мэдээллийн сан бүрдүүлэх; 4. Нөхцөл байдлыг үнэлж, дүгнэх, гарсан дүгнэлт, шийдвэрт үндэслэн хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; 5. Орон нутгийн албаны штаб, мэргэжлийн ангийг сургаж дэдлагажуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах; 6. Тухай бүр төлөвлөгөөнд тодотгол хийх; 7. Коронавируст халдварын нөхцөл байдлын мэдээ, мэдээлэл, улсын албаны шийдвэрийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, холбогдох улсын болон орон нутгийн алба, байгууллага, иргэдэд шуурхай хүргэх; 8. Штабын бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд нөхөн томилгоо хийж, ОБЕГ-т тухай бүр тодотгон хүргүүлэх. 	
ГХЭМУА-ны Шуурхай баг	<ol style="list-style-type: none"> 1. ГХЭМУА, штабын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, нэгдсэн мэдээллээр шуурхай хангах, хариу арга хэмжээнд оролцох; 	



Зохихон Байгууллагтын
Бүтцийн нэгж

Чиг үүрэг

ГХЭМУА-ны Багийн зохицуулагч	<ol style="list-style-type: none"> ГХЭМУА-ны Штабын даргын баталсан ажиллах журмыг мөрдөж, ажил үүргийн дагуу холбогдох үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах; Харьяа байгууллагуудын Шуурхай удирдлагын нэгжүүдтэй холбогдох, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;
ГХЭМУА-ны Шуурхай	<ol style="list-style-type: none"> Шуурхай багийн ерөнхий удирдлагыг ханган, хэсгүүдийн үйл ажиллагаа болон хүний нөөцийн төлөвлөлтийг уялдуулан зохицуулах; Шуурхай багийн үйл ажиллагаатай холбоотой үүрэг, даалгаврыг дэд зохицуулагч болон гишүүдэд өгөх; Шуурхай багийн үйл ажиллагаа болон үүссэн нөхцөл байдалтай холбоотой мэдээллээр ГХЭМУА-ны Штабын даргыг тогтмол ханган ажиллах; Шуурхай багийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах саналыг ГХЭМУА-ны Штабын даргад танилцуулж, шийдвэр гаргуулах; ГХЭМУА-ны дарга болон Штабын даргад өгөх нэгдсэн мэдээ, тайланг баталгаажуулах.
ГХЭМУА-ны Багийн дэд зохицуулагч	<ol style="list-style-type: none"> Шуурхай багийн хэсгүүдийг шууд удирдлагааар хангах; Шуурхай баг, хэсгүүдийн өдөр тутмын нэгтгэсэн мэдээ, мэдээлэл, тайланг хянан баталгаажуулах; Шуурхай багийн үйл ажиллагааны нэгтгэсэн үр дүнг зохицуулагчид танилцуулах; Зохицуулагчийн эзгүйд түүний чиг үүргийг шууд орон гүйцэтгэх; Дайчлагдан ажиллах ажилтнуудад хийх ажлын чиглэлийг танилцуулах.
ГХЭМУА-ны Багийн Төлөвлөгт, Хяналтын хэсэг	<ol style="list-style-type: none"> Хариу арга хэмжээний болон хүний нөөцийн төлөвлөгт, тодотгол тогтмол хийх; Эрсдэлийн үнэлгээ хийхэд оролцох, хамтран ажиллах; Шуурхай багийн өдөр тутмын ажлын төлөвлөгөөг хэсгүүдээс авч нэгтгэн, дэд зохицуулагчаар багтлуулж, биелэлтийг хангуулах; Шуурхай багийн хэсгүүдийн өдөр тутмын шинэчлэгдэн ирэх тайлан мэдээг нэгтгэж, цахим мэдээний сан үүсгэх; Шуурхай багийн үйл ажиллагааны явц, үр дүнг хянаж, дэд зохицуулагчид танилцуулах; Хэсгүүдээс гаргасан өдөр тутмын мэдээнд дүн шинжилгээ хийж, төлөвлөгтөд тусгах; Шуурхай багийн бүрэлдэхүүний ажлын цагийн тооцоог бүртгэх; Штабын чиг үүрэгтэй холбоотой ирсэн албан бичиг, өргөдөл гомдлыг хүлээн авч, хариу өгөх ажлыг зохион байгуулах.
ГХЭМУА-ны Багийн Хариу Хэмжээний хэсэг	<ol style="list-style-type: none"> Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой аливаа асуудлыг шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулах; Эмнэлгийн орны нөөцийн бэлэн байдлыг хангах, нэмэлтээр ор дэлгэх зохицуулалт хийх; Эрүүл мэндийн байгууллагуудын чадавх, хүний нөөц, нөхцөл байдлын мэдээ, мэдээллийг нэгтгэх;



Зохион байгуулалтын
бүтцийн нэгж

Чиг үүрэг

ГХЭМУА-ны Санхүү, нөөц, хангалтын хэсэг	<ol style="list-style-type: none"> Дайчлан ажиллуулах эрүүл мэндийн ажилтныг хуваарилах, зохицуулах, эрсдэлд өртөхийн өмнө болон дараагийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах; Тандаглын нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангах; Халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж, нэгжүүдэд ажиллах багуудыг мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангах.
ГХЭМУА-ны Шуурхай багийн Санхүү, нөөц, хангалтын хэсэг	<ol style="list-style-type: none"> Хариу арга хэмжээний чиглэл, цар хүрээ, шаардагдах нөөцийг батлагдсан аргачлалд тулгуурлан тооцоолох; Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуур, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгсэл зэргийн нөөцийн мэдээг өдөр тутам шинэчилж, мэдээний сан үүсгэх; Нөөцийн мэдээг өдөр бүр гаргаж, хангалт нэмж хийх шаардлагатай бараа, бүтээгдэхүүний талаарх мэдээллийг Штабын удирдлагад танилцуулж, нөхөн хангалт хийх.
ГХЭМУА-ны Шуурхай багийн Мэдээлэл, харилцаа холбооны хэсэг	<ol style="list-style-type: none"> Нөхцөл байдлын мэдээ, мэдээллийг хүлээн авч, нэгтгэх; Харьяа байгууллагуудаас ирүүлэх өдөр тутмын мэдээ, мэдээллийг нэгтгэж, удирдлага, хэсгүүдийг мэдээллээр хангах; УОК-ын Шуурхай штаб болон бусад яам, агентлагтай мэдээлэл солилцох, хамтран ажиллах; Яаралтай мэдээллийг хүлээн авсан дарууд дэд зохицуулагчид шуурхай мэдээлэх; Штабын оператор, туслахын үүрэг гүйцэтгэх; Иргэдээс дуудлагаар ирсэн санал, хүсэлтийг зохицуулах; Иргэд, олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааг системтэй зохион байгуулах.
ЭЭХХЭГ	<ol style="list-style-type: none"> Шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, хуваарилах, түгээх, зарцуулалтад хяналт тавих; Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуур, тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгсэл зэргийн нөөцийн мэдээг өдөр тутам шинэчилж, мэдээний сан үүсгэх; Хангалт нэмж хийх шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн талаарх мэдээллийг ГХЭМУА-нд танилцуулж, нөхөн хангалт хийх; Цартахалтай холбогдуулж хуваарилагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зөв зохистой захиран зарцуулах, хяналт тавьж, тайлагнах; Шаардлагатай заавар, зөвлөмж, журмыг ДЭМБ, ЭМЯ, бусад холбогдох мэргэжлийн байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу боловсруулж, батлуулж мөрдөж ажиллах.
ХӨСҮТ	<ol style="list-style-type: none"> Салбар хооронд мэдээ, мэдээлэл солилцох, эрсдэлийн үнэлгээг зохион байгуулж хийх, хариу арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх зэрэг асуудлаар салбар хоорондын байгууллагуудтай хамтарч ажиллах; Цаг үеийн мэдээ, тайланг зааврын дагуу гаргаж, УОК, ЭМЯ, Шуурхай штаб, бусад холбогдох байгууллага, иргэдийг мэдээллээр хангах;



	<ol style="list-style-type: none"> 3. Бүх шатны эрүүл мэндийн болон холбогдох бусад салбарын байгууллагуудыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах, сургалт зохион байгуулах; 4. Улсын хэмжээнд вирус судлалын лабораторийн бэлэн байдлыг хангах; 5. Коронавирус халдварын талаар шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, үнэлэлт, дүгнэлтийг бусад салбартай хамтран хийж, сайн туршлага, сургаж зэргийг баримтжуулж түгээх.
<p>ЗӨСҮТ</p>	<ol style="list-style-type: none"> 1. Суурин болон явуулын вирус судлалын лабораторийн бэлэн байдлыг хангаж, лабораторийн шинжилгээ хийх; 2. КОВИД-19-оос урьдчилан сэргийлэх болон голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийх талаар тусгай зөвшөөрөл бүхий ААН байгууллагуудтай хамтран ажиллах, зохицуулах; 3. КОВИД-19-ын голомтолд шуурхай хариу арга хэмжээний багийг томилон ажиллуулах; 4. Ариутгал, халдваргүйжүүлэх бодисын нөөцийн судалгаа хийж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх; 5. Мал эмнэлэг болон холбогдох бусад байгуулалатай хамтран КОВИД-19-ын тандлагтыг мал, амьтны дунд хамтран зохион байгуулах.
<p>НЭМҮТ</p>	<ol style="list-style-type: none"> 1. КОВИД-19-ын эрсдэлийн харилцаа холбооны арга хэмжээг үндэсний түвшинд зохион байгуулах; 2. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд тогтмол тандалт хийж, тухай бүр тайлбар, залруулга хийх; 3. КОВИД-19-ын талаар иргэдэд мэдээлэл өгөх 119 тусгай дугаарын утсыг ажиллуулах; 4. КОВИД-19-ын лабораторийн бэлэн байдлыг хангаж, лабораторийн шинжилгээ хийх.
<p>ЭМХТ</p>	<ol style="list-style-type: none"> 1. Хариу арга хэмжээний хүний нөөцийн төлөвлөлт, тодотгол тогтмол хийх; 2. Эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн мэдээ, мэдээллийг нэгтгэх; 3. Дайчлан ажиллуулах эрүүл мэндийн ажилтны төлөвлөгөөг гарган, тогтмол шинэчилж, хуваарилах, зохицуулах; 4. Резидент эмч, анагаахын чиглэлээр суралцаж буй төгсөх ангийн оюутан, сайн дурьд ажилтнуудын судалгааг гарган, дайчлан ажиллуулах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх; 5. Дайчлан ажиллуулах эрүүл мэндийн ажилтнуудыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах, сургалтад хамруулах.
<p>Орон нутгийн гамшгаас хамгаалах эрүүл мэндийн алба</p>	<ol style="list-style-type: none"> 1. Орон нутагт цартахалттай тэмцэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах; 2. КОВИД-19-ын тандалт, тусламж үйлчилгээг нэгдсэн зохицуулалтаар хангах мэргэжлийн багийн оум, дүүрэг бүрт байгуулан ажиллуулах; 3. Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй эмнэлгийн орыг КОВИД-19-ын багтаагдсан тохиолдлыг хэвтүүлэн эмчлэхээр дайчлах, үндсэн тусламжийн зохицуулалтыг хийх;




Зохион байгуулалтын
бүтцийн нэгж

Чиг үүрэг

Аймаг, дүүргийн хару арга хэмжээний баг	
4.	Дайчлан ажиглуулах эрүүл мэндийн ажилтныг хуваарилах, зохицуулах, эрсдэлд өртөхийн өмнө болон дараагийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах;
5.	Дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах;
6.	Шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, хуваарилах, тгээх, зарцуулалтад хяналт тавих;
7.	Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжлийн удирдлагаар хангах.
1.	Дүүргийн лабораторийн бэлэн байдлыг хангаж, цэгийн болон тандалтын шинжилгээг хийж, өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах;
2.	КОВИД-19-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдол бүртгэгдсэн даруйд лабораториос тандалтын багт мэдээлж, харуу арга хэмжээг шуурхай зохион байгуулах;
3.	Батлагдсан тохиолдлыг эрмбэлэн ангилж, холбогдох эрүүл мэндийн байгууллага, тусгаарлах байранд хүргэх ажлыг зохион байгуулах;
4.	Эмнэлгийн орны төлөвлөлтийн саналыг боловсруулан, холбогдох мэргэжлийн байгууллагад тухай бүр хүргүүлэх;
5.	Харуу арга хэмжээний багийн хувийн хамгаалах хэрэгсэл, бодис, эм, урвалжийн нөөцийн судалгааг гарган, бэлэн байдлыг хангах.




ХАВСРАЛТ 2. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ТАНДАЛТ, ХАВЬТЛЫН СУДАЛГААНЫ ЗУРАГЛАЛ, АЛГОРИТМ



tandalt.gov.mn

Өрхийн бус хавьтал судалгаа



tandalt.gov.mn

- Гэрийн тусгаарлалтад 14 хонохыг зөвлөнө.
- ЭЗМТ-өөс 6 дахь хоногт шинжилгээ авна.
- Эмнэлзүйн шинж тэмдэг илэрвэл харгалзахгүй шинжилгээ авна.



ХАВСРАЛТ 3. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ТУСГАЙ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

Зэрэглэл	Өдөр тутмын бэлэн байдал	Өндөржүүлсэн бэлэн байдал	Бүх нийтийн бэлэн байдал
Түвшин	I	II	III
	Халдвар илрээгүй	Зөвөвлөгдсөн, алаг цоог тархалттай	Халдвар голомтот тархалттай
			Халдвар хүн амын дунд өргөн тархсан
Хичээллэх горим	Хэвийн (халдвараас сэргийлэх дэглэм баримтлах)	Бүх насны хүүхдийг хамруулах	Бүх насны хүүхдийг хамруулах
Анги/бүлэг дүүргэлт	Хэвийн (халдвараас сэргийлэх баримтлах)	Анги дүүргэлт 20 хүртэл хүүхэдтэй бол хүүхэдтэй явуулах, 20-иос дээш хүүхэдтэй бол 1 ангид 20 хүүхэдтэй байхаар зохицуулах	Анги дүүргэлт 20 хүртэл хүүхэдтэй бол хэвийн явуулах, 20-иос дээш хүүхэдтэй бол 1 ангид 20 хүртэл хүүхэдтэй байхаар зохицуулах
Сургалтын хэлбэр	Танхимаар	Танхимаар	<ul style="list-style-type: none"> - Сургалтын хөлимог хэлбэр (цахим, танхим) - Эцэг, эхийн сонголтгоор
Хязгаарлах хичээл	Хэвийн (халдвараас сэргийлэх баримтлах)	Хэвийн (халдвараас сэргийлэх баримтлах)	<ul style="list-style-type: none"> - Дулааны улиралд биеийн тамир, (онол, хөнгөн дасгал, хөдөлгөөн), дуу хөгжим (онол)-ийн хичээлийг гадна талбайд хүн хоорондын зай баримтлан зохион байгуулах
Хичээл хаах	ТҮР Шаардлагагүй	Шаардлагагүй	<ul style="list-style-type: none"> - 1 ангид 1 хүүхэд өвчилбөл 14 хоногийн хугацаагаар зайн сургалтаар хичээллэх - Өвчлөл гарсан ангийн байрлалаас хамаарч хэсэгчлэн (корпус, давхар) хаах



<p>Шилжилт хөдөлгөөн</p>	<p>“Улаан, улбар шар, шар” тархалттай бус, нутгаас ирсэн бол 14 хоног гэрт нь тусгаарлах</p> <p>Хүүхдийг лабораторийн шинжилгээнд хамруулж сөрөг тохиолдолд шууд хичээлд оруулах</p> <ul style="list-style-type: none"> - Өөр хоорондоо хамааралгүй, (анги болон багш солигддоггүй, хамт хичээллээгүй...) 3 болон түүнээс дээш бүлгийн дотор халдвар бүртгэгдвэл цэцэрлэгийг бүхлээр нь зайн сургалтад шилжүүлэх
<p>Ерөнхий зохион байгуулалт</p>	<p>Хүүхдийг лабораторийн шинжилгээнд хамруулж сөрөг тохиолдолд шууд хичээлд оруулах</p> <ul style="list-style-type: none"> - Цэцэрлэгийн бүх хаалгыг бүрэн ашиглах - Тандалт судалгаа хийх, хавьтал тодорхойлох баг байгуулах - Хувцас солих өрөөнд эцэг, эх, асран хамгаалагчдыг олноор бөөгнөрөл үүсгэхгүй байхаар зохицуулах; - Хүүхдүүдэд коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх мэдээлэл сурталчилгааг хийх <ul style="list-style-type: none"> o Багш хичээл эхлэхийн өмнө 3-5 минут халдвараас сэргийлэх зөвлөмж, мэдээллийг өгөх o Сурталчилгааны материал байршуулах o Чанга яригч ашиглан мэдээлэл хүргэх o Эцэг эхчүүдэд халдвараас сэргийлэх зөвлөмж өгөх - Эцэг, эх, багш, суралгчдыг олон нийтийн арга хэмжээ (тэмцэн уралдаан, хурал цуглаан...) хамруулсан үйл ажиллагааг зохион байгуулахгүй байх - Эцэг, эхийн хурлыг цахимаар хийх - Үйл ажиллагаа эхлэх, тарах цагийг 10-15 минутын зөрүүтэй зохион байгуулах - Хүүхдийг унтуулахдаа “хөл-толгой” зарчим баримтлах - Хүүхдийн толгоом, хичээлийн хэрэгслийг оройд угааж, цэвэрлэх - Угааж цэвэрлэхэд хялбар цөөн тооны толгоом хэрэглэх - Багш, ажилчид коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины бүрэн тунд хамрагдсанаас хойш 14 хоногийн хугацаа өнгөрсөн байх - Хүндэтгэх шалтгаанаар коронавируст халдварын эсрэг вакцинд хамрагдаагүй багш, ажилтныг хөдөлмөр зохицуулалт хийж, цахим хичээл заах зэрэг хүүхэдтэй шууд харьцахгүй ажил хийлгэх - Багш ажилтнууд дотоод орчинд амны хаалт зүүх, 2 цаг тутамд болон бохирдсон үед солих - Ирцийн тандалт хийх, ирээгүй тохиолдолд шалтгааныг тодруулах - Өглөө бүр бүх хүүхдэд шинж тэмдгийн тандалт хийж биеийн халууныг хэмжих - Өглөө бүр хүүхдийн хамар, хоолойг сод, давс, нимбэгний уусмалын аль нэгээр зайлуулах - Халуурах, ханиалгах, нус гоожих зэрэг халдварын эмнэл зүйн шинж тэмдэг илэрсэн хүүхдийг цэцэрлэгт хүлээн авахгүй, гэрт нь буцаах
<p>Багш, ажилтнуудад тавигдах шаардлага</p>	<p>Багш, ажилчид коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины бүрэн тунд хамрагдсанаас хойш 14 хоногийн хугацаа өнгөрсөн байх</p>
<p>Эрт илрүүлэг</p>	<p>Хүндэтгэх шалтгаанаар коронавируст халдварын эсрэг вакцинд хамрагдаагүй багш, ажилтныг хөдөлмөр зохицуулалт хийж, цахим хичээл заах зэрэг хүүхэдтэй шууд харьцахгүй ажил хийлгэх</p>

